БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музей 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/108/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор сум 2019 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ... 3

2 Аудитын тайлан ... 5

2.1 Оршил ... 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ... 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ... 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ... 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ... 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ... 8

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ... 8

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ... 9

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ... 8

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ... 8

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ... 8

2.11 Шилэн дансны мэдээлэл ... 11

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ... 11

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ... 11

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ... 11

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 11

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 12

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 14

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 16

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 16

# 1 АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/121

танай ______________-ны №______________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТҮҮХ УГСААТНЫ ЗҮЙ-БАЙГАЛИЙН МУЗЕЙН ЗАХИРАЛ А.МАНДАХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музей 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музей 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музей 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем

2519228

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

# АУДИТЫН ТАЙЛАН

## 2.1 ОРШИЛ

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн захирал А.Мандах-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 23-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй, байгалийн музей нь Соёлын үйлчилгээ, музей үйл ажиллагааны хүртээмжийг дээшлүүлж, Монгол зан заншил, уламжлаа хүүхэд залууст өвлүүлэн уламжлуулах, нийгмийн хөгжлийн түүхийг баримтжуулан хамгаалах, үйлчилгээний шинэ хэлбэрийг нэвтрүүлэн, иргэдийн соёлын

биет болон биет бус өвийн мэдлэгийг дээшлүүлж, танин мэдэхүйн мэдээлэл сургалт сурталчилгааны төв болоход оршино.

.Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийн тухай хууль, ”Гар урлал болон урлалын зориулалттай зүйлс, Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага” MNS 5634 стандартыг хэрэгжүүлэхэд чанарын ахиц гарган, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэн, сан хөмрөгөө баяжуулан, түүх өв соёлоо сурталчлан соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, шинэ ажил үйлчилгээг нэвтрүүлэн, ард иргэдийн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд нүүдлийн үзэсгэлэн гаргах зөөврийн том, жижиг 2 гэртэй болсны үр дүнд хөдөөгийн 12 сумын иргэд, наадам, цэргийн баяр, тэмдэглэлт бусад арга хэмжээний хүрээнд аймгийн төвийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ажиллахаар үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад  Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 161433,7 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3228,6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилгүй, 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудалд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 2 | 1063,3 |
| | Дүн | 2 | 1063,3 |

**2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

1. Аудитын явцад 2 ажилтны цалингаас ндш-ыг 8.8,11 хувиар суутгах байсныг 7.8, 10 хувиар тус тус тооцож цалингаас суутган зөрүү 74.3 мянган төгрөгийн шимтгэлийг байгууллагаас төлсөн, НД-д Насан-тогтохын илүү цагийн хөлс 103.9 мянган төгрөгийг дутуу, Бодь-гэрэлийн цалинг 40.0 мянган төгрөгөөр илүү мэдээлж 33,0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.
2. Цахилгааны зардалд 829,9 мянган төгрөгийг баримтгүй илүү шилжүүлсэн, мөн Холбоо, интернетийн төлбөрийг шилжүүлэхдээ нэхэмжлэхийн дүн дээр, төлбөрийн баримтын дүнг нэмж 126,1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн, авлагаар тусгаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" , Нийгмийн даатгалын тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох.

## 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

**2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 146779,1

мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 146399,7 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь Байгууллагын дулааны шугамд шинэчлэл хийсэнтэй холбоотой тогтмол зардал 209,9 мянган төгрөг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр 168,6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн.

Тайлан онд дотоод орлогын төлөвлөгөөг 765,0 мянган төгрөг буюу 1,3 хувиар давуулж биелүүлсэн байна.

### 2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс хугацаа хоцорч мэдээлсэн 11 мэдээлэл байна.

### 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланд зөвлөмж аваагүй байна.

### 2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,963,969.00** | **21,768,141.01** |
| **33** | **АВЛАГА** | 1,187,781.00 | 1,187,781.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,187,781.00 | 1,187,781.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,187,781.00 | 1,187,781.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 15,776,188.00 | 20,580,360.01 |
| **351** | **Түүхий эд материал** | 190,000.00 | 190,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 190,000.00 | 190,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,586,188.00 | 20,390,360.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,363,435.00 | 1,612,235.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,953,651.00 | 15,682,823.01 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,263,602.00 | 3,089,802.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,500.00 | 5,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,048,069,169.13** | **1,408,140,824.36** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,048,069,169.13 | 1,408,140,824.36 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,048,069,169.13 | 1,314,140,824.36 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 461,616,210.00 | 393,794,452.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -326,049,669.51 | 00.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19,000,000.00 | 19,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -11,874,999.79 | -13,774,999.75 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 52,914,544.00 | 56,304,434.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -47,443,291.92 | -47,786,445.36 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 42,922,668.58 | 42,922,668.58 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -31,134,247.98 | -32,809,836.70 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 877,641,985.00 | 889,981,985.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,148,840.00 | 9,852,755.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,974,873.25 | -7,446,193.29 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 3,200,000.00 | 00.00 |
| 39217 | Ном | 4,102,004.00 | 4,102,004.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 94,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,370,000.00 | 1,370,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,370,000.00 | -1,370,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 94,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,065,033,138.13** | **1,429,908,965.37** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **739,425.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 739,425.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 739,425.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 758,225.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | -18,800.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | -18,800.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,065,033,138.13** | **1,429,169,540.37** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,065,033,138.13 | 1,429,169,540.37 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 382,396,106.72 | 476,396,106.72 |
| 51101 | Өмч: - төрийн | 382,396,106.72 | 476,396,106.72 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -115,791,236.05 | 106,465,542.36 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -115,791,236.05 | -115,791,236.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 222,256,778.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 798,428,267.46 | 846,307,891.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,065,033,138.13** | **1,429,908,965.37** |

## 1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **160,474,884.00** | **383,661,025.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,500,280.00** | **224,008,579.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,500,280.00 | 224,008,579.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,495,500.00 | 224,008,579.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,495,500.00 | 3,265,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 220,743,579.00 |
| 120009 | Бусад орлого | 4,780.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **8,586,304.00** | **15,373,346.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 149,388,300.00 | 144,279,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,000,000.00 | 2,714,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,714,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,000,000.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 10,279,890.00 |
| 133003 | Хөрөнгийн | 00.00 | 10,279,890.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4,586,304.00 | 2,378,956.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4,586,304.00 | 2,378,956.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **169,718,112.05** | **158,233,746.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **169,718,112.05** | **158,233,746.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 161,984,796.05 | 154,710,415.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 95,267,276.00 | 88,309,183.00 |
| 210101 | Үндсэн цалин | 95,267,276.00 | 88,309,183.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,088,401.00 | 22,590,817.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,281,655.00 | 22,590,817.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 804,672.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 502,920.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 201,170.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,297,984.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 10,878,220.00 | 25,600,038.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,833,220.00 | 3,840,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 21,760,038.99 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 45,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,285,077.00 | 3,272,939.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,683,876.00 | 684,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 456,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 455,094.00 | 1,071,189.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 265,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 667,950.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 11,146,107.00 | 127,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,900.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,900.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,870,773.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,870,773.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 482,800.00 | 519,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 482,800.00 | 519,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,907,200.00 | 1,807,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,545,200.00 | 1,494,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 169,300.00 | 169,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 112,900.00 | 112,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,800.00 | 31,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,747,149.05 | 12,610,937.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 29,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,747,149.05 | 12,581,437.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,733,316.00 | 3,523,331.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,733,316.00 | 2,378,956.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 3,233,316.00 | 2,378,956.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 4,500,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 1,144,375.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,144,375.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-9,243,228.05** | **225,427,278.41** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 29,500.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 00.00 | 29,500.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 3,200,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 3,200,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -3,170,500.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-9,243,228.05** | **222,256,778.41** |

## 1.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **156,608,604.00** | **152,637,556.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,000,000.00** | **3,265,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,000,000.00 | 3,265,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 3,265,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 3,265,000.00 |
| 120009 | Бусад орлого | 4,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **152,608,604.00** | **149,372,556.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 149,388,300.00 | 144,279,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 2,714,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,714,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,220,304.00 | 2,378,956.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 3,220,304.00 | 2,378,956.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **156,608,604.00** | **152,637,556.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **156,608,604.00** | **152,637,556.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **148,786,872.00** | **149,114,225.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 100,381,942.00 | 99,017,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 100,381,942.00 | 99,017,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,042,400.00 | 11,882,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,034,423.00 | 9,522,530.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 501,304.00 | 1,286,193.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 918,959.00 | 286,531.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 584,958.00 | 71,557.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,002,756.00 | 715,289.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,861,296.00 | 24,972,714.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,276,796.00 | 3,840,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,539,500.00 | 21,132,714.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 45,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,708,494.00 | 4,297,189.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 975,650.00 | 759,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,583,200.00 | 1,442,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 566,094.00 | 1,305,249.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 265,000.00 | 340,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 318,550.00 | 449,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 309,000.00 | 309,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 309,000.00 | 309,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,265,400.00 | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,265,400.00 | 600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 482,800.00 | 519,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 482,800.00 | 519,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,735,540.00 | 7,516,022.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,316,840.00 | 7,073,922.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 169,300.00 | 169,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 112,900.00 | 112,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 136,500.00 | 61,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 18,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 80,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,821,732.00** | **3,523,331.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,733,312.00 | 2,378,956.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 3,233,312.00 | 2,378,956.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 4,500,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 88,420.00 | 1,144,375.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 88,420.00 | 1,144,375.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 1.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 382,396,106.72 | 798,428,267.46 | -106,548,012.00 | 00.00 | 1,074,276,362.18 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **382,396,106.72** | **798,428,267.46** | **-106,548,012.00** | **00.00** | 1,074,276,362.18 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -9,243,228.05 | 00.00 | -9,243,228.05 |
| C08 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **382,396,106.72** | **798,428,267.46** | **-115,791,236.05** | **00.00** | 1,065,033,138.13 |
| D01 | **2017оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **382,396,106.72** | **798,428,267.46** | **-115,791,236.05** | **00.00** | 1,065,033,138.13 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **382,396,106.72** | **798,428,267.46** | **-115,791,236.05** | **00.00** | 1,065,033,138.13 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 47,879,623.83 | 00.00 | 00.00 | 47,879,623.83 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 94,000,000.00 | 00.00 | 222,256,778.41 | 00.00 | 316,256,778.41 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **476,396,106.72** | **846,307,891.29** | **106,465,542.36** | **00.00** | 1,429,169,540.37 |

## 1.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 149,888,300.00 | 149,875,852.00 | 146,779,100.00 | 146,399,725.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 149,888,300.00 | 149,875,852.00 | 146,779,100.00 | 146,399,725.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 147,388,300.00 | 147,375,572.00 | 146,779,100.00 | 146,399,725.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 100,383,900.00 | 100,381,942.00 | 99,017,900.00 | 99,017,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 100,383,900.00 | 100,381,942.00 | 99,017,900.00 | 99,017,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,042,400.00 | 11,042,400.00 | 11,882,100.00 | 11,882,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,026,900.00 | 7,034,423.00 | 7,866,700.00 | 9,522,530.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 803,200.00 | 501,304.00 | 1,003,800.00 | 1,286,193.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,003,800.00 | 918,959.00 | 803,100.00 | 286,531.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 200,800.00 | 584,958.00 | 200,800.00 | 71,557.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,007,700.00 | 2,002,756.00 | 2,007,700.00 | 715,289.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,862,200.00 | 24,861,296.00 | 25,182,700.00 | 24,972,714.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,277,700.00 | 12,276,796.00 | 3,840,000.00 | 3,840,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,347,900.00 | 12,539,500.00 | 21,000,000.00 | 21,132,714.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 236,600.00 | 45,000.00 | 342,700.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,842,500.00 | 3,708,494.00 | 3,841,200.00 | 3,841,189.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 756,800.00 | 975,650.00 | 756,800.00 | 759,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,753,200.00 | 1,583,200.00 | 986,200.00 | 986,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 434,200.00 | 265,000.00 | 1,306,000.00 | 1,305,249.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 446,000.00 | 265,000.00 | 340,000.00 | 340,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 452,200.00 | 318,550.00 | 452,200.00 | 449,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 309,700.00 | 309,000.00 | 309,700.00 | 309,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 00.00 | 309,700.00 | 309,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,265,400.00 | 1,265,400.00 | 600,000.00 | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,265,400.00 | 1,265,400.00 | 600,000.00 | 600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 519,300.00 | 482,800.00 | 519,300.00 | 519,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 519,300.00 | 482,800.00 | 519,300.00 | 519,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,762,900.00 | 2,735,560.00 | 5,426,200.00 | 5,257,522.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,316,700.00 | 2,316,840.00 | 4,980,000.00 | 4,815,422.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 169,300.00 | 169,300.00 | 169,300.00 | 169,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 112,900.00 | 112,900.00 | 112,900.00 | 112,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 61,100.00 | 61,000.00 | 61,100.00 | 61,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 18,800.00 | 18,800.00 | 18,800.00 | 18,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 84,100.00 | 56,700.00 | 84,100.00 | 80,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2400000.00 | 2400000.00 | 0.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,400,000.00 | 2,400,000.00 | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4500000.00 | 4500000.00 | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,500,000.00 | 4,500,000.00 | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,500,000.00 | 4,500,000.00 | 00.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 149,888,300.00 | 149,875,852.00 | 146,779,100.00 | 146,399,725.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 149,888,300.00 | 149,875,852.00 | 144,279,100.00 | 143,134,725.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 149,888,300.00 | 149,875,852.00 | 144,279,100.00 | 143,134,725.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,500,000.00 | 2,500,280.00 | 2,500,000.00 | 3,265,000.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,500,000.00 | 2,500,280.00 | 2,500,000.00 | 3,265,000.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 00.00 | 00.00 | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 00.00 | 00.00 | 01.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 00.00 | 00.00 | 15.00 | 15.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 | 07.00 | 07.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07.00 | 07.00 | 07.00 | 07.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **15.00** | **15.00** | **15.00** | **15.00** |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 06.00 | 06.00 | 10.00 | 10.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 09.00 | 09.00 | 05.00 | 05.00 |